

НЭРТ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ ОНХОД ОВОГТ САНГАРАВЫН ЖАМЬЯН (1864-1930)

Г.Долингор, Э.Даваадулам

Хөдөө аж ахуйн их сургууль, Суурь боловсролын төв

И-мэйл: dolingor5 @yahoo.com

ХУРААНГУЙ

Монголын орчин цагийн шинжлэх ухааны байгууллагыг үүсгэн байгуулсан эрдэмтэн С.Жамьян Цэцэн хан аймгийн Ачит вангийн хошууны ард Сангаравын гэрт 1864 онд төрсөн. С.Жамьян багаасаа нутгийн сэхээтэн Билэгтэд шавь орж, гэрийн сургалтаар монгол, манж, төвд үсэг бичигт тайлагдаж, хошуу тамгын газрын тал бичээчээс Богд хаант Монгол Улсын Сангийн яамны дэд сайд, улмаар Ардыг гэгээрүүлэх яамны анхны сайд, Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайдаар тус тус тохоон томилогдож явсан баялаг түүхтэй хүн юм. Тэрбээр орон нутаг, нийслэл хүрээнд бичиг дансны ажил эрхлэн онцгой зүтгэл гаргасны учир Их шавийн яамнаас “Зайсан” тушаал олгож, улмаар “Улсад туслагч гүн”-гийн хэрэг хэргэм хүртээжээ.

1921 оны Ардын хувьсгалын дараа шинэ цагийн соёл, боловсролыг дэлгэрүүлэх үйлсэд сайд Жамьянгийн идэвх оролцоо нэн чухал байжээ. С.Жамьян бол орчин үеийн Монголын шинжлэх ухааны анхны байгууллагыг үүсгэн байгуулж, хөгжүүлэн дэлгэрүүлэх, үндэсний утга соёлын өв уламжлалыг хайрлан хамгаалах, түүхийн дурсгалт зүйлийг судлан сурвалжлах, хойч залуу үеийг сурган хүмүүжүүлэх, монгол хэл бичгийн судлалын бүтээл туурвих үйлсэд бие лагшин, сэтгэл зүрх, билиг авьяасаа бүрэн зориулсан их соён гэгээрүүлэгч мөн.

ТҮЛХҮҮР ҮГ: хүрээлэн, академи, номын сан, архив, ардыг гэгээрүүлэх яам, сайд, судлаач, мал эмнэлэг

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Их бичгийн хүмүүн хэл шинжлэлийн гарамгай эрдэмтэн, соёлын өв судлаач, шилдэг багш, төрийн зүтгэлтний амьдрал, зохиол бүтээл, санаачилж хийсэн ажлыг бодит үнэнээр нь судалж, хойч үеийнхэндээ дамжуулан үлдээх зорилготой. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг тавьсан болно.

- С.Жамьян судлаачдын ганц сэдэвт болон суртчилгааны өгүүлэлтэй танилцаж харьцуулалт хийх
- Үндэсний архив, Үндэсний номын сангийн ховор чухал ном бүтээлүүдтэй танилцан тэдгээрийн хадаглалт хамгаалалт ашиглалтын талаар судлах

СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

Судалгаанд шинжлэх ухааны ерөнхий арга болох: Эх бичиг судлах аргыг түлхүү ашиглан, С.Жамьян судлалын эрдэмтэд Э.Пүрэвжав, Д.Төмөртоогоо, Д.Цэрэнсодном, Б.Энхтүвшин нарын ном, өгүүлэлд гарсан баримтыг түүвэрлэн

авч судалгааны объект болгон уншиж судлан, фокус группын ярилцлага, харьцуулалт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг ашигласан болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Нэг. Шинэ Монголын шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэгч. Ардын хувьсгалын дараахан тэр үеийн хэсэг сэхээтэн санаа нийлэн, ард түмнээ бичиг үсэг, соёл боловсролтой болгож, соён гэгээрүүлэхийн тул юуны өмнө шинжлэх ухааны зүйл бүрийн салбарыг үүсгэн хөгжүүлэх зорилгоор "Номын хүрээлэн" байгуулах санал боловсруулж, шинэ тутам байгуулагдсан Ардын Засгийн газарт өргөн барьжээ. Засгийн газар уул хүсэлтийг 1921 оны 11 дүгээр сарын есний өдөр хэлэлцэн сайшаасны дагуу Ж. Цэвээн, гүн Жамьян, Д.Дашням, түшмэл Ч.Бат-Очир нар бүгд 15 зүйлтэй дүрмийн үндсийг боловсруулжээ. "Монгол Улсын судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо" хэмээх тэрхүү дүрмийн оршилд "Эдүгэ буй манай Судар бичгийн хүрээлэн байн байсаар хөгжин дэлгэрч, ухаан бүгдийг бүртгэсэн ба уран сайхны ажлыг хуран цогцлоосон АКАДЕМИ болж чадах буй за" хэмээн дурдсан нь шинээр байгуулагдсан Хүрээлэнгийнхээ алс ирээдүйг хэрхэн төсөөлж байсныг илтгэж байна. Тэрхүү дүрмийг Засгийн газрын 1921 оны 11 дүгээр сарын хуралдаанаар хэлэлцэн батлаад, Номын хүрээлэнгийн эрхэлсэн сайдаар гүн Жамьян, нарийн бичгийн даргаар түшмэл Ж.Цэвээн нарыг тохоон томилж, үйл ажиллагаанд нь зориулж эхний ээлжинд 3000 лан мөнгө шийтгэн олгож байжээ. Ингэж Монгол Улсын шинжлэх ухааны анхны бие даасан байгууллага болох Судар бичгийн хүрээлэн анх 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, нэн түрүүнд байгалийн баялаг, эртний хөшөө дурсгал, хуучны эд өлгийн зүйлс, ховор нандин ном судрыг сурвалжлан цуглуулах, данслан бүртгэх, хадаглан хамгаалах, монгол хэл, түүх, соёл, шашин мөргөлийн түүхийг уламжлан судлах зорилт тавин ажиллажээ. Энэхүү зорилттой уялдуулан 1924 онд түүхийн кабинет, орон нутаг судлах музей зэргийг нэмэн байгуулсан байна.

Хориод оны дунд үе хүртэлх хэдхэн жилийн дотор Лигдэн хааны үед хулсан үзгээр бичсэн "Ганжуур" болон "Хаадын үндэсний эрдэнийн

эрх", "Арван буянт номын цагаан түүх, "Зүрхний тольттын тайлбар,"Хэлний чимэг,"Мянган бурханы нэр"Богд Чингэс хааны тууж,"Юань улсын түүх" зэрэг олон чухал ном судрыг цуглуулсан байна. 1926 онд Нууц товчооны олон зүйлийг багтаасан Лувсанданзан гүүшийн "Алтан товч" гэж алдаршсан хосгүй ховор сурвалж бичгийг Юншээбуу отогт харьяалагддаг, боржигон овгийн Дамдин гэдэг хүнээс авч, гадаадын нууц товчоо судлаачдад мэдээлж, 1937 онд Улаанбаатар хотноо хэвлүүлэн гаргасан нь нууц товчоо гагцхүү хятад дүрс үсгээр тэмдэглэгдэн үлдсэн хэмээх үзэл баримтлалыг өөрчилснөөр үл барам энэ гайхамшигт дурсгалт бичиг анх монгол хэлнээ уйгаржин монгол үсгээр бичигдсэний нэгэн баталгаа гэж эрдэмтэд үздэг болсон юм.

ЮНЕСКО-гийн "Дэлхийн дурсамж" хөтөлбөрийн олон улсын зөвлөлдөх хорооны 2011 оны X бага хурлын шийдвэрээр Лувсанданзаны хэмээн олноо алдаршсан "Алтан товч" (1651), "Монгол Данжуур"-ыг дэлхийн хосгүй үнэт баримтат өвөөр бүртгэж, албан ёсны батламж гэрчилгээг Монгол Улсад гардуулсан нь их бичгийн хүмүүн Жамьян гүнгийн анхлан сэдэж санаачилсан, соёлт хүмүүн төрөлхтөний түүхэнд үл мартагдах гавьяат үйлс байсныг онцлож байна.

Судар бичгийн хүрээлэнгийн хамгийн анхны нэгж нь дуун ухааны (хэлбичиг) тасаг байсан бөгөөд хожим 1924 онд түүх-газарзүйн тасаг, 1927 онд Улсын архивыг нэмэн байгуулж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Хоёр. С.Жамьян нэрт соён гэгээрүүлэгч багш. Монгол, манж, төвд хэлээр туурвисан дорнын мэргэдийн зохиол бүтээл, бурхан багшийн сургаал номлолоос аваад Саганцэцэний "Эрдэнийн товч" тэргүүтэй түүхэн сурвалж бичиг, равжимба Данзандагвын "Зүрхний тольтын тайлбар, Огторгуйн маань" лхарамба Агваандандар "Монгол үсгийн ёсыг сайтар номлосон хэлний чимэг" тэргүүтэй хэлзүйн зохиолуудыг уншиж судалсан эрдэмтэн хүний

хувьд зохиол бүтээлдээ өмнөх мэргэдийн ном зохиолыг өргөн ашигладаг байжээ.

Тэрбээр анх 1924 онд “Монгол үсгийн аймаг, анхан сурах хөвгүүдийн амыг нээх Тодорхой толь” хэмээх анхныхаа бүтээлийг хорголжин бараар хэвлүүлж олноо түгээсэн нь бичиг үсэг сурах үнэтэй чухал гарын авлага болжээ. Мөн Монгол үсгийн цагаан толгой оршив”(1922), “Монгол үсэг зурах бага хөвгүүдийн сурлагыг удирдах мөрийн бичиг хэмээх цагаан толгой оршив. (1927), “Монгол үсэгт сургах цагаан толгой хэмээх дэвтэр (1928), зэрэг анхан шатны сурах бичиг зохион гаргаснаас “Монгол үсгийн ёсыг өчүүхэн төдий товчлон гаргасан байдал (1921)”, “Анх сурах хөвгүүд, охидыг удирдан сургах хичээлийн бичиг (1925) зэрэг монгол хэлний сурах бичгүүдийг удаа дараалан боловсруулан хэвлүүлжээ. Бичгийн их хүмүүн Жамьян хүн ардаа бичиг үсэгтэй, эрдэм боловсролтой болгох чин эрмэлзлэлийн үүднээс”Тоо бодлогыг анхлан сурагчдын зам” хэмээх номыг боловсруулан хэвлүүлсэн бөгөөд түүний энгийн тооны үйлдлүүд болон тэдгээрийн сампин дээр бодох аргуудыг их л нарийчлан таниулсан байжээ.

Гурав. Түүхч, судлаач. С.Жамьян дээр дурдсан хэлзүйн бүтээлүүдээс гадна монгол үндэстний түүхэнд холбогдох хэд хэдэн өгүүлэл бичсэн. Энд “Урт өдрийн улиг үгний бичиг”(1925) хэмээх зохиолыг дурдаж болно. Энэ нь хэмжээгээр багахан боловч хүн төрөлтний бичиг үсэг анх үүссэн үеэс аваад монголбичиг үүсэн хөгжсөн бүх түүхийг үгүүлсэн бүтээл юм. Зохиогч энэхүү бүтээлийнхээ зорилгын талаар : “Хичээнгүйлэн санаваас дэлхий дахины олон овгийн улс өөр өөрийн хэлний үсгийг хэдийд, хэн гэдэг нэртэй хүн зохиосон явдал цөм тодорхой данс буй хэмээнэ. Манай Монгол улсад өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг гаргасан номлол буй боловч ихэд дэлгэрсэн нь үгүй бөгөөд хүн бүр олж мэдэж чадаагүй тул “Сая сурах бага хөвгүүдэд өчийхэн тус болохыг эрэн хүсч, манай Монголд өөрийн хэлний үсэг хэрхэн дэлгэрсэн учрыг ...” хэмээн дурдаад монгол бичиг үсэг, уламжлалт хэл зүйн бичгүүд хийгээд уйгар, хятад, төвд, орос, манж, али, гали, тод үсгийн талаар бичсэн байна. Тэрбээр гадаад хэлийг төрөлх хэлнийхээ суурин дээр тулгуурлан сурахыг чухалчлан: “Эрдэм соёл юугаа бадруулахыг нэн ихэд хичээж, насан залуу сэргэлэн багачуудыг гадаадын хэлбичгийн сургуульд явуулж бүхий нь нэн ч сайшаалтай бөгөөд гагцхүү өөрийн үндэстний монгол

бичгийг урьдаас сураваас зохионо.” хэмээн энэ номондоо дурдсан бий.

Мөн түүнчлэн манжийн төрийн үеийн хууль цаазын холбогдолтой 400 шахам дэвтэр цаас эмхмэлийг цэгцэлсэн төдийгүй “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” гэсэн 65 дэвтэр шинээр боловсруулалцаж, эмхэтгэсэн нь эдүгэ архивын үнэт материал болж байна.

Түүний өөр нэг сонирхолтой судалгаа нь их эзэн Чингис хааны мэндэлсэн газрыг тодруулах зорилготой судалгаа юм. 1928 онд хээрийн судалгааны ажлаар Хан Хэнтий, Онон мөрний сав нутгаар дөчөөд хоног аялсаар хуучин гилбэр харуулын нутаг хүрч, тэндэхийн ахмад хүмүүсээс Чингэс хаантай холбогдох уул усны домог, хууч яриаг тэмдэглэн авч, нутгийн газарчинтай хамт Гурван нуур, Баян-Овоо, Онон, Балж голын бэлчир, Тэнгэлэг гол хавийн газраар явж, газрын байцын тухай тэмдэглэн үлдээсэн нь цаашид их хааны мэндэлсэн газрыг тогтооход үнэтэй чухал хэрэглэгдэхүүн болно. Монголчууд төрт ёсны түүхийн баялаг уламжлалтай.Түүх бол аргамж бас сургамж гэдгийг бид мартаж болохгүй.

Дөрөв. Төр нийгмийн зүтгэлтэн С.Жамьян. Ардыг гэгээрүүлэх яамны анхны сайдаар С.Жамьянг 1924 оны 2 дугаар сард тохоон томилов. Яам байгууллагдсанаар өмнө нь Гадаад хэргийн яам, Дотоод хэргийн яамны түшмэдийн хүрээгээр хязгаарлагдаж байсан боловсрол, шинжлэх ухаан, соёлын олон талт ажлыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлсэн юм. Яамны сайдын 24 дүгээр тушаалаар “Багшийг бэлтгэх сургууль” үйл ажиллагаагаа эхэлсэн нь багш бэлтгэх, давтан сургах ажлыг эрчимжүүлэв. Ууган сайдын эхлүүлсэн гэгээн зам улиран буй 90 жилийн хугацаанд амжилт, ололт, хямрал, тэмцлийг даван туулж эдүгээгийн Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрийг хүртэл өөдөө тэмүүлж 28 дахь сайдын бодлого үйл ажиллагаа манай салбарт хэрэгжиж байна. Сайдын 2014 оны А/225 тоот тушаалаар энэ хичээлийн жилээс эхлэн Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах нийгэм, хүмүүнлэгийн чиглэлийн дөрвөн хичээлийг нийт 12 багц цагаар судлах шийдвэр гаргасан нь цагаа олсон, хэрэгцээг мэдэрсэн шийдэл болов.

С.Жамьян ухамсартай сэхээтнийхээ хувьд ч, Сангийн яамны дэд сайдынхаа хувьд ч эдийн засгаа засгаа хөгжүүлэх чинь сэтгэлийн үүднээс нөөц бололцоогоо ашиглаж, арвилан хэмнэх, хэрэглээнээсээ илүү, орлогоосоо дээгүүр

хээнцэрлэхийг хязгаарлах тухай өргөх бичиг боловсруулан, Олноо өргөгдсөний зургадугаар /1916/ онд Улсын доод хуралд оруулан хэлэлцүүлж байсан байна. Түүгээр ч барахгүй, “Эдийн засгийн үндсэн бодлого” гэсэн төрийн бодлогын чанартай хөтөлбөрийг боловсруулахад Б.Цэрэндорж, Ж.Цэвээн нартай хамтарч 1923 оны 7сарын Засгийн газрын хуралдаанаар батлуулж байжээ. Уг баримт бичигт: тус улсын аж ахуйн үндсэн салбар мал аж ахуйг хөгжүүлэхийг гол болгон үндэсний аж үйлдвэрийг байгалийн баялгийг ашиглах ба малаас гарах түүхий эдийг боловсруулах гэсэн 2 чиглэлээр байгуулах, тариалан, зам, гүүр, тээвэр холбооны ажлыг үүсгэх, худалдааны ажлыг сайжруулах, МХТХоршоог хөгжүүлэх, банк байгуулж үндэсний мөнгөн тэмдэгт гаргах,

ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

Судалгаанд “Эх хэлээ эрхэмлэх нийгэмлэг”-ээс эрхэмлэн гаргадаг Эх хэл бичиг сэтгүүлийн редакцын гишүүд, ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэд, Монгол судлалын холбооны зарим судлаачдын бүтээлийг судалж, нүүр тулан ярилцаж, санал, бодол, дүгнэлтээ танилцуулж, зарим шүүмж, зөвлөгөөг авч бодит баримтанд тулгуурласан өгүүлэл билээ. С.Жамьян бол Орчин цагийн боловсрол,

ДҮГНЭЛТ

ЮНЕСКО-гийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн олон улсын зөвлөлдөх хорооны 2011 оны X бага хурлын шийдвэрээр Лувсанданзаны хэмээн олноо алдаршсан “Алтан товч” (1651), “Монгол Данжуур”-ыг дэлхийн хосгүй үнэт баримтат өвөөр бүртгэж, албан ёсны батламж гэрчилгээг Монгол Улсад гардуулсан нь их бичгийн хүмүүн Жамьянгийн анхлан сэдэж санаачилсан, соёлт хүмүүн төрөлхтөний түүхэнд үл мартагдах гавьяат үйлс байсныг онцлон тэмдэглэе.

ТАЛАРХАЛ

Монголын шинжлэх ухааны ажилтны өдрийг угтан Мал эмнэлгийн хүрээлэнгээс санаачлан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг уламжлал тогтож, эрдэмтэн судлаачдыг урьж илтгэл хэлэлцүүлэх боломж олгосонд талархаж байна. Энд өгүүлэн буй мятаршгүй хөдөлмөрч,

санхүү төсөв, данс бүртгэлийн системийг буй болгох асуудлыг тодорхой тусгажээ. Мөн үйлдвэрийн боловсон хүчнийг гадаад улсуудад сургаж бэлтгэх, хөдөлмөрийн чадвартай иргэдийг лам, хар гэж ялгаварлахгүйгээр нийгмийн бүтээн байгуулалтад оролцуулах нь чухал гэж үзэж байсан нь одоо ч ач холбогдолтой хэвээр байна.

Эдийн засгаа сэргээх үндэс болсон мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч, 1923 оны 4-р сард мал сүргийг эмчлэх ажлыг улсын болгож, Сангийн яамны дэргэд Мал эмнэлгийн хэлтсийг байгуулж, ЗХУ-аас 5 мэргэжилтнийг урьж ажиллуулсан төдийгүй, 1924 онд мал эмнэлгийн ажилтан бэлтгэх түр сургуулийг нээж байсан байна.

шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэгч түүний анхны дүрэм, журмыг боловсруулагч, эдүгэгийн Үндэсний номын сан, Үндэсний архив, Үндэсний түүхийн музейн эхийг тавилцсан их бичгийн эрдэмтэн, соёлын өвийг сурвалжлан олж, тээн дамжуулагч, ахмад эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч гэдгийг архив болон бичгийн баримт, хамтран зүтгэгчдийн дурсамж яриа, дүрст зураг зэргээр нотолсонд оршино.

Их бичгийн хүмүүн, нэрт соён гэгээрүүлэгч, С.Жамьян бол ХХ зууны Монголын төр улсыг төвхнүүлэхээс эхлээд шинэ цагийн шинжлэх ухаан, боловсролыг үүсгэн хөгжүүлэх үйлсэд бие, хэл, сэтгэлээ бүрэн зориулсан төрийн нэрт зүтгэлтэн, хэл бичгийн гарамгай эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч, үндэснийхээ нэн чухал соёлын өвийг хамгаалан тэмцэгч, эх оронч, үндэсний сэхээтэн мөн.

авьяаслаг эрдэмтний талаар бие оюунаа чилээж бүтээл туурвилаа зориулсан эрдэмтэн судлаачдаа баярлаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд Та нарын доорх бүтээлийг ашигласан болохыг онцлон дурдая.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Э.Пүрэвжав, Их эрдэмтэн Онходын Жамьян. УБ, 2014он
2. Н.Пүрэвжав, Монголын нууц товчоо гэдэг нэрийг уламжилж тогтоосон нь УБ, 2002 он
3. Ж.Болдбаатар , Монгол Улсын түүх, V боть.УБ., 2003 он
4. Монгол Улсад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 90 жил. (Эмхэтгэж редакторласан , Б.Бэгз ЭШБХ, УБ., 2014он
5. Д.Цэрэнсодном нарын , “Эх хэл бичиг” сэтгүүл. УБ. 2014он. №6
6. Д.Төмөртогоо. Шинэ Монголын шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэгч Онходын Жамьян . “Эх хэл бичиг” сэтгүүл. УБ. 2014он . №6
7. www.google.mn

ABSTRACT

Jamyans.S, establishing initial modern time organization of Mongolian Science, developed, propagated it and protected and he is a enlightener and all his life for caring national culture, tradition, study and research on historical and memorial, train for young people and wrote many research works of Mongolian language study.